



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/144

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дүүргийн 2 дугаар хорооны Нуур, Замчин гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох “Сервис центр” дэд төвийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Г.Дагвадорж	Дүүргийн менежер
Гишүүд:	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Б.Батхуяг	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичиг:	Г.Одонбаатар	Хөрөнгө оруулалт, орон нутгийн өмч, сургалт тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн

2.Гүйцэтгэгч нь захиалагчаас гаргасан ажлын даалгавар, мэргэжлийн байгууллагаас гаргасан зураг төсөвт тусгагдсан тоо хэмжээний дагуу чанар үр дүнтэй гүйцэтгэж байгаа эсэхийг нарийвчлан хянаж холбогдох шаардлагыг тавьж тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Г.Дагвадорж)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2024 он ажил/захирамж

1123200400